

## **НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

Багануур дүүрэг нь эдийн засаг, эрх зүйн шинэ орчин бүрдсэн, иргэнээ дээдэлсэн, баялаг бүтээгчдээ дэмжсэн, үйлдвэрлэл хөгжсөн, амьдралын ая тухтай, амар тайван, байгальд ээлтэй, ил тод нээлттэй бие даасан хот болно.

### **НЭГ. ЭДИЙН ЗАСАГ, ЭРХ ЗҮЙН ШИНЭ ОРЧИН БҮРДСЭН ХОТ**

#### **Эрх зүй, засаглалын чиглэлээр:**

- 1.1 Бие даан хөгжих эдийн засаг, эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- 1.2 Төр, захиргааны байгууллагаас гаргах шийдвэрт иргэдийн оролцоог хангаж ажиллана.
- 1.3 Багануур дүүргийг 2030 он хүртэл хөгжүүлэх ‘Хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө’-г батлуулж, хэрэгжүүлнэ.
- 1.4 Нээлттэй, хариуцлагатай засаглалын бодлого хэрэгжүүлж, нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд тавих хяналтыг тогтмолжуулж, ажлын уялдаа холбоог сайжруулна.
- 1.5 Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох үйл ажиллагааг ил тод болгоно.
- 1.6 Төрийн албыг мэргэшсэн, чадварлаг хүний нөөцөөр бүрдүүлж, “Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр” хэрэгжүүлнэ.
- 1.7 Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт үе шаттайгаар шилжүүлж, хороодоос иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.
- 1.8 Төрийн архивын хадгалалт, хамгаалалтын орчин нөхцөлийг сайжруулна.
- 1.9 Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

#### **Эдийн засаг, төсөв санхүүгийн чиглэлээр:**

- 1.10 “Багануур үйлдвэрлэл, технологийн парк”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 1.11 Эдийн засгийн үр ашигтай гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж хамтран ажиллана.
- 1.12 Төсвийн орлогын бааз суурийг нэмэгдүүлнэ.
- 1.13 Төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг оновчтой болгож, төсвийн сахилга батыг сайжруулна.
- 1.14 Хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудад иргэдийн саналыг тусгаж, төсөл арга хэмжээ, худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод болгож, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулна.

#### **Хүрэх үр дүн:**

Бие даан хөгжих эдийн засаг, эрх зүйн шинэ орчин бүрдэж, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоо нэмэгдэн, төрийн үйлчилгээ иргэдэд цогц, хүртээмжтэйгээр хүрч, төсвийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналт сайжирч ил тод нээлттэй болно.

## **ХОЁР. ИРГЭНЭЭ ДЭЭДЭЛСЭН ХОТ**

### **Эрүүл мэндийн чиглэлээр:**

- 2.1 Иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэж, эх хүүхдийн эрүүл мэндэд онцгой анхаарч, салбарын байгууллагуудыг оношлогоо, эмчилгээний орчин үеийн тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангана.
- 2.2 Эрүүл мэндийн байгууллагын бүтэц зохион байгуулалт, цахим үйлчилгээг боловсронгуй болгож, эмч эмнэлгийн ажилчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулан чадавхжуулж, үйлчилгээний соёлыг дээшлүүлнэ.
- 2.3 Нийгмийн эрүүл мэндийг бэхжүүлж, иргэдийг амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх зөв дадал хэвшилд сургана.
- 2.4 Өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл амьдрах ухаанд сургана.
- 2.5 Өрхийн эрүүл мэндийн төвийн стандарт хангасан, лабораторийн тоног төхөөрөмж бүхий барилга барьж ашиглалтад оруулна.

### **Боловсрол, соёл, биеийн тамир спортын чиглэлээр:**

- 2.6 Боловсролын чанарын шинэчлэлийн хүрээнд сургуулийн өмнөх боловсрол, бага, суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлж сургалтын чанарыг дээшлүүлнэ.
- 2.7 Боловсрол, сургалтын байгууллагуудын орчин нөхцөлийг сайжруулж, стандартад нийцүүлнэ.
- 2.8 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үе тэнгийнхэнтэйгээ хамт суралцах нийгэм сэтгэл зүй, сургалт, дэд бүтцийн таатай орчинг бүрдүүлнэ.
- 2.9 Боловсролын салбарын багш, ажиллагсдын мэргэжил ур чадварыг дээшлүүлэх, урамшуулах, ажиллах нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.
- 2.10 “Боловсролын зээлийн санг”-ийн сургалтын төлбөрийн зээлд оюутнуудыг хамруулна.
- 2.11 “Гүн-Галуутай” цогцолбор сургуулийг их зохиолч Д.Нацагдоржийн нэрэмжит болгоно.
- 2.12 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг байгуулж, төрөлжсөн нарийн мэргэжилтэй ажиллах хүчнийг бэлтгэнэ.
- 2.13 320 хүүхдийн суудалтай бага сургуулийн барилгыг ашиглалтад оруулна.
- 2.14 Насан туршийн боловсролын төвөөр олгох сургалтын чанар, хүртээмжийг сайжруулж, төвийн барилгыг барьж ашиглалтад оруулна.
- 2.15 Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгын ажлыг эхлүүлнэ.
- 2.16 850 хүний суудалтай Соёлын ордны барилгыг барьж, соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулан, орон нутгийг судлах танхимын үзмэрийг баяжуулна.
- 2.17 Нийтийн биеийн тамираар хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж, иргэдийн бие бялдрын хөгжлийн асуудалд түлхүү анхаарч, секц, дугуйлангийн үйл ажиллагааг дэмжиж, спортын холбоод, салбар зөвлөлүүдтэй хамтран ажиллана.
- 2.18 Жендэрийн эрх тэгш байдлыг хангаж ажиллана.

### **Хүүхэд, залуучууд, гэр бүлийн чиглэлээр:**

- 2.19 Хүүхдэд ээлтэй бодлогыг хэрэгжүүлж, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог нэмэгдүүлнэ.

- 2.20 Хүүхэд залуучуудын хөгжлийн асуудалд түлхүү анхаарч, авьяас чадварыг нээн хөгжүүлнэ.
- 2.21 Хүүхдийг амьдрах ухаан, бие даах чадвар, харилцааны зөв дадал хэвшилд төлөвшүүлэх “Хүн болох багаасаа” аян өрнүүлнэ.
- 2.22 “Оюунлаг Багануур” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.23 Хүүхдийн зуслангийн менежментийг боловсронгуй болгоно.
- 2.24 Залуучуудын сурч боловсрох, хөдөлмөрлөх таатай орчинг бүрдүүлж, манлайллыг нэмэгдүүлэн, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог хангана.
- 2.25 Хүүхэд, залуучуудад үндэсний өв уламжлал, эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх, хотын соёлд суралцуулах, гэр бүлийн боловсрол олгож, чөлөөт цагийн орчин нөхцөлийг сайжруулах санал санаачилгыг дэмжиж хамтран ажиллана.
- 2.26 Залуучууд, залуу гэр бүлийг “Орлогод нийцсэн-Орон сууц” хөтөлбөрт хамруулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.
- 2.27 Дэлхийн зөн болон олон улсын байгууллагатай хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ.

### **Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн чиглэлээр:**

- 2.28 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Нэг өрх-нэг ажлын байр” хөтөлбөр хэрэгжүүлэн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн 1000-аас доошгүй иргэнийг тогтвортой ажлын байраар хангаж, хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлнэ.
- 2.29 Нийтийн эзэмшлийн дэд бүтцийг сайжруулах, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн ажлын байрыг дэмжиж 1200-аас доошгүй иргэнийг ажлын түр байраар хангана.
- 2.30 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн 250-аас доошгүй мэргэжилтэй ажилчин бэлтгэнэ.
- 2.31 “Итгэлийн зээл” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ.
- 2.32 Зорилтот бүлгийн иргэдийн санал санаачилгыг дэмжин төсөл хөтөлбөрт хамруулан ажлын байртай болгож, өрхийн орлогыг нь нэмэгдүүлнэ.
- 2.33 Өрхийн амьжиргааны түвшинг шинэчлэн тогтоож, зорилтот бүлгүүдийг оновчтой тодорхойлон “Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн, 148-аас доошгүй өрхийн амьжиргааг дээшлүүлнэ.
- 2.34 Ахмад настны эрүүл мэндийг дэмжих, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчинг бүрдүүлж, ахмад мэргэжилтний Зөвлөх үйлчилгээг дэмжинэ.
- 2.35 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийн стандартыг хангаж, нийгмийн амьдралд оролцох нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.36 Орон гэргүй, тэнэмэл, ажил эрхэлдэггүй, нийгмийн харилцаанаас тусгаарлагдаж болзошгүй иргэдэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ.

### **Хүрэх үр дүн:**

Хүн амд үзүүлэх нийгмийн суурь үйлчилгээний орчин, хүний нөөцийн чадавх сайжирч, эрүүл мэнд, боловсрол, соёл, урлаг, биеийн тамир, хөдөлмөр эрхлэлт, халамж, нийгмийн хамгааллын үйлчилгээний хүртээмж нэмэгдэн, иргэдийн амьдралын чанар дээшилнэ.

## **ГУРАВ. БАЯЛАГ БҮТЭЭГЧДЭЭ ДЭМЖСЭН, ҮЙЛДВЭРЛЭЛ ХӨГЖСӨН ХОТ**

- 3.1 Үйлдвэрлэл технологийн паркийн хүрээнд нано технологи, аж үйлдвэрийн цогцолбор байгуулж, томоохон болон жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх замаар эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх бодлого барьж ажиллана.
- 3.2 Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтыг нь бодлогоор дэмжиж ажиллана.
- 3.3 Ахуйн үйлчилгээний салбарт ажиллагсдын мэргэшил мэдлэгийг дээшлүүлж, орчин нөхцөлийг сайжруулна.
- 3.4 Орчин үеийн шаардлагад нийцсэн Худалдааны төв байгуулах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- 3.5 Хөдөө аж ахуй, газар тариалан эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжийг дэмжиж, хүн амын хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлэн, газрын ашиглалтыг сайжруулна.
- 3.6 Малчид болон мал бүхий иргэдэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх бодлогыг хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлэх, малын түүхий эд, мах, сүү, сүүн бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэн, эрчимжсэн мал аж ахуйг дэмжинэ.
- 3.7 Хүнсний аюулгүй байдлыг хангах итгэмжлэгдсэн лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж, эрсдлээс сэргийлнэ.
- 3.8 Багануурын дулаан цахилгаан станцын хөрөнгө оруулалтын ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 3.9 Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг бий болгох нарны цахилгаан станцын төслийг хэрэгжүүлнэ.
- 3.10 Гадаадын хөрөнгө оруулалттай, орчин үеийн дэвшилтэт технологи бүхий ноос гүн боловсруулах эко үйлдвэрийн ажлыг дэмжиж эхлүүлнэ.

### **Хүрэх үр дүн:**

Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд бизнесийн таатай орчин бүрдэж, төр хувийн хэвшлийн түншлэл болон гадаадын хөрөнгө оруулалт, тогтвортой ажлын байр нэмэгдэн, эдийн засгийн чадавх сайжирч, хүнсний аюулгүй байдал хангагдана.

## **ДӨРӨВ: АМЬДРАЛЫН АЯ ТУХТАЙ, АМАР ТАЙВАН ХОТ**

- 4.1 Амины болон нийтийн орон сууцнуудыг шинээр ашиглалтад оруулж, иргэдийг орон сууцаар хангах бодлого хэрэгжүүлнэ.
- 4.2 Айл өрх, аж ахуйн нэгжийг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбох, гэр хорооллын гудамж талбайг сайжруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 4.3 Авто замын сүлжээг өргөтгөх, замын байгууламжыг сайжруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 4.4 Нийтийн орон сууцны хороолол дундах инженерийн шийдэл бүхий авто зогсоол барих ажлыг эхлүүлнэ.
- 4.5 Гэр болон орон сууцны хорооллын гэрэлтүүлэг, хяналтын камерын тоог нэмэгдүүлж иргэдийн аюулгүй байдлыг хангана.
- 4.6 Иргэдийн амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх зам талбай, ногоон байгууламж бүхий хүүхдийн тоглоомын талбайг орон сууц, гэр хороололд нэмэгдүүлнэ.
- 4.7 Бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг эхлүүлнэ.
- 4.8 Нийтийн орон сууцны дээвэр, гадна дулаалга, инженерийн шугам сүлжээний ашиглалтыг сайжруулна.

- 4.9 Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмж, соёлыг сайжруулна.
- 4.10 Эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах, шинэ техник технологи нэвтрүүлэх чиглэлээр төслийг хэрэгжүүлж, айл өрхийн цахилгаан хангамжийн асуудлыг иж бүрэн шийдвэрлэнэ.
- 4.11 Гамшиг осол, галын аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтсүүдийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.
- 4.12 Цагдаагийн хэлтсийн ажлын байрыг барьж ашиглалтад оруулна.
- 4.13 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг татан оролцуулж, эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.
- 4.14 Архи, согтууруулах ундаа, тамхи худалдан борлуулахад тавих хяналтыг эрчимжүүлж, архи, тамхигүй орчинг бий болгох санал санаачилгыг дэмжинэ.
- 4.15 Гэрч хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах “Хамгаалах байр”-ыг бий болгоно.
- 4.16 Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авто замын уулзвар, гарцыг өргөтгөх, гэрэлтүүлэг, дохиолол, тэмдэг тэмдэглэгээг сайжруулна.
- 4.17 Батлан хамгаалах төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжид холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг тусалцаа үзүүлнэ.

#### **Хүрэх үр дүн:**

Иргэдийн аюулгүй, амар тайван ажиллаж амьдрах таатай орчин нөхцөл бүрдэж, төр иргэний хамтын ажиллагаа сайжирна.

### **ТАВ. БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ НОГООН ХОТ**

- 5.1 Нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 5.2 Орчны бохирдлыг бууруулж, хог хаягдлын менежментийг сайжруулна.
- 5.3 Хэрлэн гол бусад гол горхи, булаг шандны эх, ойн сан бүхий газрыг хамгаалах, нөхөн сэргээх бодлого боловсруулан иргэд, төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 5.4 Гэр хорооллын айл өрхийн цэвэр усны хангамжийг нэмэгдүүлнэ.
- 5.5 Хөрс, ус, агаарын хяналт шинжилгээний чадавхыг бэхжүүлж, байгаль орчны мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, олон нийтэд хүргэх мэдээллийг сайжруулна.
- 5.6 Төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын найдвартай ажиллагааг хангана.
- 5.7 Гэр хорооллын айл өрхийн цахилгаан эрчим хүчний шөнийн хэрэглээний үнийг тэглэнэ.

#### **Хүрэх үр дүн:**

Нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдэн, байгаль орчны бохирдол буурч, иргэд эрүүл, эко орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.